



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 1/203

Улаанбаатар хот

Г  
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм,  
бүтцийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 8 дугаар зүйлийн 8.1.4, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын “Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай” 2012 оны 50, Монгол улсын Засгийн газрын “Тогтооолд өөрчлөлт оруулах тухай” 2015 оны 376 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан дүрэм, бүтцийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 79 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



080010



Эрүүл мэндийн сайдын  
2016 оны 12 сарын 06 -ны өдрийн  
... дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “Төв” гэх) нь эрүүл мэндийн салбарын хууль, бодлого, хөтөлбөр, стратеги, дүрэм, журам, стандарт, удирдамжийг боловсруулахад шаардлагатай бодлогын судалгаа хийх, сургалт явуулах, шийдвэр гаргагчдыг нотолгоо, статистик тоо, мэдээллээр хангах, холбогдох хууль, тогтоомж, сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног, төхөөрөмж, тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэл, эрүүл мэндийн ажилтны хөгжил, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, салбарын зайн анагаах ухаан, мэдээллийн технологи, эрүүл мэндийн удирдлага, хөгжлийн асуудалтай холбоотой бодлогын хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага мөн.

1.2. Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

1.3. Байгууллагын оноосон бүтэн нэр нь “Эрүүл мэндийн хөгжлийн төв”, оршин байгаа газар нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны гудамж- 13Б

1.4. Төвийн нэрийг англи хэл дээр “Center for Health Development” гэнэ.

1.5. Энэ дүрмийн зорилго нь Төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тогтоон хяналт тавих, эд хөрөнгийн эрх, түүнээс үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино. Энэхүү дүрэм нь Төвийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, санхүүжилттэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах баримт бичиг мөн.

1.6. Төв нь өөрийн бэлгэдэл /эмблем/-тэй байх бөгөөд тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

1.7. Энэ дүрмийн 1.6-д дурдсан тэмдгээр байгууллагын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

1.8. Засгийн газрын шийдвэрээр төвийг өөрчлөн байгуулах буюу татан буулгана.

### **Хоёр. Төвийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим**

#### **2.1. Төвийн зорилго**

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, байгууллага, хүний нөөц, техник технологи, тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, салбарын удирдлага, манлайллыг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

#### **2.2. Төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг**

Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас доор дурдсан чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах, зохион байгуулахад нь мэрэгжлийн дэмжлэг туслалцаа, судалгаа, дүн шинжилгээ, мэдээ мэдээллээр хангаж ажиллах үндсэн чиг үүрэг хүлээнэ. Үүнд:

2.2.1. Эрүүл мэндийн салбарын тогтолцооны болон бодлогын судалгаа, хууль тогтоомж, бодлогын шийдвэрийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн болон үндэсний тооцоо хийх, салбарын манлайлал, удирдлагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэх асуудал;

2.2.2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл, алсын зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх асуудал;

2.2.3. Эмнэлгийн багаж, техник, тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн мэдээний санг бүрдүүлэх, судалгаа, хяналт, тохишуулга, баталгаа, ашиглалт, засвар, үйлчилгээг хийх асуудал;

2.2.4. Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаа;

2.2.5. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарын хөгжил, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа;

2.2.6. Эмийн бүртгэл, зөвшөөрөл олгох, сургалт, судалгаа, хяналт хийх, мэдээний сан бүрдүүлэх, мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.2.7. Байгууллагын үйл ажиллагааг, төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, захиргаа, санхүү, үйлчилгээ болон эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтанд хамрагдах хугацаанд байраар хангах үйл ажиллагаа.

### 2.3 Төвийн үйл ажиллагааны зарчим:

- 2.3.1. Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- 2.3.2. Үйлчлүүлэгчийг дээдэлж, үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- 2.3.3. Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцыг чанд сахих;
- 2.3.4. Ил тод, нээлттэй ажиллаж, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангах;
- 2.3.6. Төрийн албан хаагчийн ёс зүй, хуулийг мөрдлөг болгох.

### Гурав. Төвийн эрх, үүрэг

#### 3.1.Төв нь дараах эрхтэй:

3.1.1.Өөрийн үндсэн үйл ажиллагааг хангахад чиглэсэн эрх зүйн баримт бичиг боловсруулан мөрдүүлэх;

3.1.2.Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудаас эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, судалгааг гаргуулан авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх;

3.1.3.Төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд салбарын бодлого, стратеги, хууль, дүрэм, журам, стандарт, тушаал, бусад шийдвэртэй холбоотой асуудлаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.4.Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг боловсруулах, батлагдсан төсвийг зөвшөөрөгдсөн бүтэц, орон тоо, байгаа нөөц, материаллаг баазад тулгуурлан хууль, журмын дагуу захиран зарцуулах;

3.1.5.Төв нь үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээний шийдвэр гаргахад зөвлөх үүрэг бүхий Удирдлагын зөвлөлтэй байна.

3.1.6.Ижил чиг үүрэг бүхий гадаадын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.1.7.Өөрийн үндсэн чиг үүргийн хүрээний асуудлаар үндэсний, бүсийн болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарыг бие даан болон хамтран зохион байгуулах;

3.1.8.Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд

өөрийн үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээ, хэлцэл байгуулан ажиллах;

3.1.9.Тогтолцооны болон бодлогын судалгаа, сургалт хийхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус “Эрдмийн зөвлөл” ажиллуулах. Энэ зөвлөлийн дүрмийг төвийн Ерөнхий захирлын тушаалаар баталгаажуулах;

3.1.10. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх зорилгоор Ерөнхий захирлын дэргэд “Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын баг”-ийг ажиллуулах;

3.1.11.Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу холбогдох судалгаа, сургалт, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.12.Өөрийн үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд гэрчилгээ, үнэмлэх, бэлгэдлийн загвар, бүртгэл, судалгааны маягтыг батлан гаргаж мөрдүүлэх;

3.1.14.Төв нь өөрийн байгууллагын шагнал, өргөмжлөл, тэмдэгтэй байна. Шагнал, урамшуулал олгох журмыг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн Ерөнхий захирлын шийдвэрээр баталгаажуулах;

3.1.15.Байгууллагын ажилтныг шагналд тодорхойлох, холбогдох дээд шатны байгууллагуудад санал тавьж, шийдвэрлүүлэх;

3.1.16.Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэд, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн мэдээ мэдээллийг түгээх зорилгоор цахим хуудас, мэдээний сан зэрэг олон нийтийн мэдээллийн сүлжээтэй байх;

3.1.17.Үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд ном, гарын авлага, эмхтгэл зэргийг гаргах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөх;

3.1.18.Хууль тогтоомжид заасан бусад эрх.

### **3.2.Төв нь дараах үүрэгтэй:**

3.2.1.Төв нь салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан байгууллагын хөгжлийн дунд хугацааны төлөвлөлтийг хийж, баталгаажуулан хэрэгжүүлэх;

3.2.2.Төвийн зорилго, үндсэн чиг үүргийн хүрээнд хууль, тогтоомж, сайдын тушаалыг хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн бусад байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Төвийн чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуурыг ханган ажиллах;

3.2.5. Байгууллага, иргэд, үйлчлүүлэгчдийг өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.2.6. Байгууллага, иргэд, үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, дүн шинжилгээ хийж, залруулах, эргэн мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.7. Нягтлан бodoх бүртгэл, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж, төсөв, санхүүжилтийн үр дүн, үр ашгийг тооцож, тайлагнах;

3.2.8. Байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

3.2.9. Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх төлөвлөгөөтэй ажиллах, эрүүл мэндийн бусад байгууллагад энэ чиглэлээр дэмжлэг үзүүлж, ажиллах;

3.2.10. Ажилтнуудынхаа нийгмийн баталгааг хангах, ажиллах дэмжлэгт орчин бүрдүүлэх талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачилгатай ажиллах;

3.2.11. Ажилтнуудынхаа мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг мөрдүүлж ажиллах, сахилга, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

3.2.12. Бусад хууль тогтоомж, дүрэм журамд заасан үүрэг.

### **Дөрөв. Төвийн удирдлага, зохион байгуулалт**

4.1. Төвийн удирдлага нь Ерөнхий захирал, дэд захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.

4.2. Төвийн дэд захирал нь үндсэн чиг үүргээс гадна даргын эзгүйд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

4.2. Төвийн Ерөнхий захирал нь төвийн үндсэн чиг үүрэг, байгууллагыг хөгжлийн төлөвлөгөө, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, энэхүү дүрэмд заасан төвийн эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.3.Удирдлагын зөвлөл нь Ерөнхий захирлын шийдвэр гаргах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зөвлөх, дэмжлэг үзүүлж ажиллана.

4.4.Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийг алба гэж нэрлэх бөгөөд нэгжийг албаны дарга удирдана.

4.5.Төвийн Удирдлагын зөвлөлийн бүтэц, ажиллах журмыг Ерөнхий захирал батална. Удирдлагын зөвлөлийг Ерөнхий захирал удирдана.

4.6. Төвийн Ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл хурлын тэмдэглэл гаргана.

#### **4.7.Ерөнхий захирлын эрх, үүрэг:**

4.7.1.Төвийн бүтэц, үндсэн чиг үүрэг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг, байгууллагын дотоод журам, хөгжлийн хөтөлбөр, ойрын болон хэтийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг байгууллагын дотоод болон үйл ажиллагаатай холбоотой журмуудыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

4.7.2.Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан нэгж, түүний орон too, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

4.7.3.Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй үр дүнгийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас халах, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, цуцлах;

4.7.4.Ажилтныг гадаад, дотоодод томилолтоор ажиллуулах, захиргааны чөлөө олгох;

4.7.5.Ажлын үр дүнг үндэслэн ажилтнуудыг шагнаж урамшуулах, хариуцлага хүлээлгэх;

4.7.6.Хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах;

4.7.7.Төвийг гадаад, дотоодод бүрэн хэмжээгээр төлөөлөх;

4.7.8.Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авлигаас ангид ажиллах;

4.7.9. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;

4.7.10. Ажилтны талаар гаргасан өргөдөл, гомдлыг дангаараа буюу холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран шийдвэрлэх;

4.7.11. Ажилтныг мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

4.7.12. Байгууллагын үндсэн чиг үүрэг, бүтцийн нэгжийн чиг үүргийн онцлогт нийцүүлэн ажлын байр, албан тушаалын чиг үүргийг нэгжийн удирдлага боловсруулж, Ерөнхий захирал баталгаажуулна.

4.7.13. Хуулиар олгогдсон бусад эрх, үүрэг.

4.8. Төв нь холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд ажилтнуудын нийгмийн хамгаалал, эрх ашгийг хамгаалах, тэдний сурч боловсроход дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Хамт олны зөвлөл”-тэй байж болно.

4.9. Хамт олны зөвлөлийн бүрэлдэхүүнийг төвийн нийт ажилтны хурлаар хэлэлцэж сонгох бөгөөд хамт олны зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүдийн олонхийн саналыг үндэслэн сонгоно. Хамт олны зөвлөлийн дарга нь төвийн удирдлагын зөвлөлийн гишүүн байна.

#### **Тав. Төвийн санхүүжилт**

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.1. Улсын төсөв;

5.2. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого;

5.3. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.4. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

#### **Зургаа. Төвийн гадаад, дотоод хамтын ажиллагаа**

6.1. Төв нь эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, яам, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх

ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.


6.2. Төв нь өөрийн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд бусад байгууллага, иргэдтэй шууд харилцана.

6.3. Гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, зочид, төлөөлөгч урих, үндсэн чиг үүргийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр гадаад харилцаагаа хөгжүүлэн ажиллана.

6.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэрээнд байгууллагаа төлөөлж, гарын үсэг зурах эрхийг Ерөнхий захирал эдэлнэ.

6.5. Төвийн Ерөнхий захирлын гадаад, дотоод томилолтыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, төвийн бусад ажилтнуудын гадаад, дотоод томилолтын асуудлыг Ерөнхий захирлын шийдвэрээр баталгаажуулна.

#### **Долоо. Төвийн зохион байгуулалтын бүтцийн тогтолцооны ерөнхий загвар, нэгжийн чиг үүрэг**



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, бүтцийн тогтолцооны ерөнхий загварыг үндэслэн

тус төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн чиг үүргийг дор дурдсанаар тодорхойлж байна:

**7.1. Бодлогын судалгаа, удирдлагын сургалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.1-ийн хүрээнд:

7.1.1. Эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлаар тогтолцооны судалгаа хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоогоор хангах;

7.1.2. Эрүүл мэндийн бодлого, хууль эрх, зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоогоор хангах;

7.1.3. Олон улсын стандартад нийцүүлэн Эрүүл мэндийн үндэсний тооцооллын тогтолцоог нэвтрүүлж, санхүүжилтийн тайлан, өртгийн судалгаа хийх, хууль эрх зүйн шийдвэрийн төслийн эдийн засгийн тооцоог хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоогоор хангах;

7.1.4. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, эрэлт, хэрэгцээний судалгаа хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоогоор хангах;

7.1.5. Эрүүл мэндийн чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбоотой үнэлгээ хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоогоор хангах;

7.1.6. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хэрэгцээний үнэлгээ, судалгаа хийх, тусгай зөвшөөрлийн комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээний санг бүрдүүлэх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоогоор хангах;

7.1.7. Эрүүл мэндийн бүх шатны байгууллагын удирдах ажилтныг бэлтгэх сургалтын хэрэгцээг судлах, үнэлэх

7.1.8. Эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг сургах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, сургалт зохион байгуулах

7.1.9. Эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх.

Энэ нэгжийн зарим чиг үүргийн хүрээнд багийн зохион байгуулалтаар ажиллаж болно. Нэгжийн үйл ажиллагаа нь эрүүл мэндийн салбарын бодлого болон эдийн

засаг, санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа, дүн шинжилгээг салбарын тэргүүлэх чиглэл, хүн амын өвчлөл эндэгдэл, эрүүл мэндийн тусlamжийн хэрэгцээ, түүний гүйцэтгэлтэй уялдуулан хийж, дээрх асуудлуудаар шийдвэр гаргахад Эрүүл мэндийн яаманд нотолгоон суурилсан мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэх, салбарын удирдах ажилтны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн удирдах ажилтныг орчин үеийн түвшинд бэлтгэж, хөгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудад засаглал, удирдлагын асуудлаар зөвлөгөө өгөх, хамтран ажиллах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ЭМЯ-ны бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага (Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга), төвийн Ерөнхий захирал, дэд захирал байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь эрүүл мэндийн яамны зохион байгуулалтын бусад нэгж, нутгийн захиргааны төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, ТББ, иргэд байна. Энэ үйлчилгээний үзүүлэхэд оролцох гол түнш нь Удирдлагын академи, АШҮҮИС-ийн НЭМ-ийн сургууль, АУХ, олон улсын байгууллага, гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллага, их дээд сургуулиуд, эрүүл мэндийн байгууллагууд, ТББ-үүд байна.

## **7.2.Статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.2-ийн хүрээнд:

7.2.1.Эрүүл мэндийн байгууллагуудын статистик мэдээг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргагчид, хэрэглэгчдэд шаардлагатай, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;

7.2.2.Өвчний олон улсын ангиллыг нэвтрүүлэх, хэрэглээг сайжруулах ажлыг зохион байгуулах;

7.2.3.Хүн амын эрүүл мэндийн мэдээний нэгдсэн цахим сан бүрдүүлэх, програм хангамжийн тогтвортой үйл ажиллагаа, аюулгүй байдал, нууцлалыг хангах;

7.2.4.Үндэсний эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, төслийн мэдээг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.2.5.Хүн амын өвчлөл, нас барагтанд тархварзүйн дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;

7.2.6.Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, чадавхижуулах;

7.2.7.Эрүүл мэндийн салбарын цахим тогтолцоог хөгжүүлэх, өвчний түүхийг цахимжуулах, алсын зайн оношилгоо, эмчилгээ болон эмнэлгүүдийн мэдээллийн

технологийг боловсронгуй болгох үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулахад төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах;

7.2.8. Салбарын нэгдсэн сүлжээ, мэдээний нэгдсэн сангуудын тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хангах;

7.2.9. Эрүүл мэндийн мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, чадавхижуулах;

7.2.10. Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн технологи, зайн анааах ухааны тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, бүртгэл, судалгааг хийх, хэрэгцээг тооцох.

Энэ нэгжийн мэдээллийн технологитой холбоотой зарим чиг үүргийн хүрээнд багийн зохион байгуулалтаар ажиллаж болно. Нэгжийн үйл ажиллагаа нь эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн мэдээллийг хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дагуу цуглуулах, боловсруулах, эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээг цуглуулах, нэгтгэх, олон улсын өвчний ангилалыг нэвтрүүлэх, хүн амын эрүүл мэндийн мэдээний сан бүрдүүлэх, зайн оношлогоо, эмчилгээний нэгдсэн сүлжээний тогтвортой үйл ажиллагааг хангах, тэдгээрийн аюулгүй байдал, нууцлалыг хангах замаар Эрүүл мэндийн яамны бүтцийн нэгжүүд, эмнэлгийн байгууллагууд, хэрэглэгчид нотолгоотой үнэн зөв мэдээллээр хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээр үйлчилүүлэх үндсэн хэрэглэгч нь ЭМЯ-ны бодлого төлөвлөлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага (Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга), төвийн Ерөнхий захирал, дэд захирал байх бөгөөд энэ үйлчилгээний шууд бус хэрэглэгч нь ЭМЯ-ны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгж, төрийн, орон нутгийн захиргааны болон эрүүл мэндийн төсөвт болон хувийн хэвшлийн байгууллагууд, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагууд, иргэд бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь төв орон нутгийн статистик мэдээллийн байгууллагууд, судалгааны байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагууд байна.

### **7.3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг 2.2.3-ын хүрээнд:

7.3.1. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үнэлгээ хийх, арга аргачлал, шалгуур үзүүлэлтийг сайжруулах;

7.3.2. Эрүүл мэндийн салбарын оношилгоо, эмчилгээнд ашиглагдаж буй эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжид шалгалт, тохируулга, засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх;

7.3.3. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай үйл ажиллагаа, түүний сэлбэг хэрэгслийн нэгдсэн тооцоо болон хэрэгцээний судалгаа хийх, мэдээллээр хангах;

7.3.4. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл, нэршил, ангиллыг олон улсын стандартын дагуу бий болгон мэдээний нэгдсэн сан үүсгэх, баяжилт хийх, мэдээллээр шийдвэр гаргагчдыг хангах;

7.3.5. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн мэргэжлийн болон ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах, заавар, гарын авлага боловсруулах, арга зүйгээр хангах;

7.3.6. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгаа, тооцоог өвчний онош эмчилгээний үр дүн, эдийн засгийн үр ашиг зэрэгт үндэслэн гүйцэтгэж, хөрөнгийн төлөвлөлт хийх, жишиг техникийн үзүүлэлт боловсруулан шийдвэр гаргагчид, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв, нотолгоотой мэдээллээр хангах;

7.3.7. Эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэц, агааржуулалт, газардуулга, цахилгаан хангамж, эмнэлгийн хийн хангамжийн тооцоо судалгаа хийх, нэгдсэн арга зүйгээр хангах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;

7.3.8. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжруулах асуудлаар тооцоо судалгаа хийж, санал боловсруулж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах;

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн салбарын багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээг судлах, оношлогоо эмчилгээнд ашиглагдаж буй эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжид шалгалт, тохируулга, засвар үйлчилгээ хийх, мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, багаж, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай үйл ажиллагаа, засвар үйлчилгээний арга зүй, удирдамжаар хангах, сэлбэг, дагалдах хэрэгслийн нэгдсэн тооцоо, судалгаа хийж, эмнэлгүүдийг мэдээллээр хангах, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл, нэршил, ангиллыг олон улсын стандартын дагуу бий болгон сан үүсгэж, хэрэглэгчдийг хангах, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, ашиглалтын талаар сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулж

хэрэглэгчдийг хангах, эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэц, агааржуулалт, цахилгаан хангамж, эмнэлгийн хийн хангамжийн тооцоо судалгаа хийж, арга зүйгээр хангах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээр үйлчлүүлэх үндсэн хэрэглэгч нь ЭМЯ-ны эм, үйлдвэрлэл технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага (Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга), төвийн Ерөнхий захирал, дэд захирал байх бөгөөд энэ үйлчилгээний шууд бус хэрэглэгч нь яамны зохион байгуулалтын бусад нэгж, эмнэлгийн байгууллагууд, оношлогооны төв, төрөлжсөн лабораториуд, олон улсын байгууллагууд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвшн нь олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид, хандив, туслалцаа үзүүлэгч нар, эрүүл мэндийн байгууллагууд байна.

#### **7.4. Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.4-ийн хүрээнд:

7.4.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааны хөтөлбөр, ажлын дэмжлэгт орчинг сайжруулах, хөгжлийн баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг Эрүүл мэндийн яаманд танилцуулж байх;

7.4.2 Эрүүл мэндийн ажилтны сургалтын хэрэгцээ, мэргэжлийн түвшин, үр чадварын судалгааг гүйцэтгэх, эрүүл мэндийн ажилтныг тасралтгүй сургах төлөвлөгөөний санал боловсруулж, шийдвэрлүүлэх, тасралтгүй сургалтын жилийн болон дунд хугацааны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

7.4.3 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтыг нэгдсэн зохион байгуултаар хангаж, эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн ажлын албаны үүрэг гүйцэтгэх, холбоотой мэдээ, тайланг нэгтгэн гаргах;

7.4.4 Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон шинэчлэх ажлыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийг үнэлэх, сургал явуулах байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагааны тогтмол хяналт хийх, резидент болон төрөлжсөн мэргэшлийн сургалт удирдах эмч-багш бэлтгэх арга зүйн сургалтыг зохион байгуулах;

7.4.5 Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, нийслэлийн дүүрэг бүрээс эмч, сувилагч, мэргэжилтнийг өндөр хөгжилтэй улс оронд сургах, өндөр үр чадвартай эмч, мэргэжилтний багийг урилгаар ажиллуулах, туршлага судлах замаар эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах гадаад сургалтын жилийн болон дунд хугацааны нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

7.4.6 Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачааллын судалгаа хийх, норм нармативыг тогтоох санал боловсруулж ЭМЯ-нд танилцуулах, төгсөгчдийг ажилд зуучлах, ажлын байраар хангах ажлыг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

7.4.7 Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг үнэлэх, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, холбоотой мэдээ, тайланг нэгтгэн гаргах;

7.4.8 Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн ажлын албаны үүрэг гүйцэтгэх, холбоотой мэдээ, тайланг нэгтгэн гаргах, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах;

7.4.9 Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын сорилын санг баяжуулах, тасралтгүй үнэлэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн цахим шалгалт, сургалтын салбар төвүүдийг мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагааг тогтмолжуулах;

7.4.10 Монгол улсад мэргэжлийн үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэдээний нэгдсэн сан бүрдүүлэх, тогтвортой үйл ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах, баяжилт хийх, гадаад орнуудын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон боловсролын түвшин, мэргэшсэнийг нотлох баримт бичгүүдийн талаарх албан лавлагааны санг бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.4.11 Салбарын хүний нөөцийн мэдээний нэгдсэн санг бүрдүүлэх, тогтвортой үйл ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах, баяжилт хийх, шийдвэр гаргагчдыг мэдээллээр тухай бүр хангаж байх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр, хөгжлийн баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагад туслалцаа дэмжлэг үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сургалтын хэрэгцээ, мэргэжлийн түвшин, ур чадварын судалгаа, үнэлгээг гүйцэтгэх, тасралтгүй сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, сургалт явуулах байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах, резидент болон төрөлжсөн мэргэжлийн сургалт удирдах эмч багш бэлтгэх, өндөр хөгжилтэй оронд мэргэжилтэн бэлтгэх, тэдгээр орнуудаас өндөр мэргэжлийн баг, мэргэжилтэн урьж сургалт явуулах, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах, салбарын хүний нөөцийн мэдээний санг бүрдүүлж, нууцлал, аюулгүй байдлыг хангах, баяжилт хийх, дээр дурьдсан үйл ажиллагаануудын үр дүнгийн талаар бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч, эрүүл мэндийн байгууллага, ажилтан, иргэдийг мэдээллээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ЭМЯ-ны төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага (сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга), төвийн Ерөнхий захирал байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамны зохион

байгуулалтын бусад нэгж, эмнэлгийн байгууллагууд, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, олон улсын байгууллагууд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь эрүүл мэндийн сургалт эрхлэгч байгууллагууд, анагаах ухааны их, дээд сургуулиуд, олон улсын байгууллагууд байна.

**7.5.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.6-ийн хүрээнд:

7.5.1.Эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

7.5.2.Эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах, хэрэглээнд тогтмол хяналт тавих;

7.5.3.Эмийн бүртгэлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж, жороор болон жоргүй олгох эм, уламжлалт эм, био-бэлдмэл, вакцин, оношуур, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хөтөлж, мэдээний сан үүсгэх, тогтмол баяжилт хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.5.4.Эм, биобэлдмэл, вакцины аюулгүй байдал /фармаковижилинс/, гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл, үнэлгээ, эм, биобэлдмэл, вакциныг улсын бүртгэлд бүртгэсний дараах болон хуурамч, стандартын бус эмийн тандалт судалгаа, эмнэлзүйн судалгааны хяналт үнэлгээ, мэдээний сан үүсгэх, тогтмол баяжилт хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.5.5.Эмийн мэдээлэл, зах зээлд таниулах үйл ажиллагааны болон зар сурталчилгааны хяналтыг тогтмол тавих, эмийн хэрэглэх зааврыг баталгаажуулах, зар сурталчилгаа хийх зөвшөөрөл олгох;

7.5.6.Эмнэлгийн мэргэжилтнүүдийг эмийг зөв хэрэглэх арга зүйгээр хангах, иргэд, олон нийтэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, антибиотикийн тэсвэржилтээс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангах, эмийн мэдээллийн сэтгүүл гаргах;

7.5.7.Үндэсний үйлдвэрийн эмийн бүтээгдэхүүний фармакопейн өгүүллийг хянах, баталгаажуулах болон инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх судалгааны мэдээний сан үүсгэх, тогтмол баяжилт хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.5.8. Эм хангамжийн байгууллагын болон эмийн бусад зохистой дадлын хяналт-үнэлгээг хийж, мэдээний сан бүрдүүлэх, тогтмол баяжилт хийх;

7.5.9. Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, хүртээмж, үнийн талаарх мэдээллийг Эм ханган нийлүүлэх байгууллага, Эрүүл мэндийн байгууллагаас авч нэгтгэх, хэрэгцээг тооцох;

7.5.10. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэх, нэгдсэн худалдан авалт зохион байгуулахад шаардлагатай мэдээллийн сан үүсгэх;

7.5.11. Эмийн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг хангах талаарх судалгаа, дүн шинжилгээ хийх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь чанарын баталгаатай аюулгүй эмийг бүртгэн, эмчилгээнд онож хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, зайлшгүй шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн хангамжийг бүрдүүлэх, эмчилгээ оношлогоонд хэрэглэх эмийн чанар, аюулгүй байдлыг хангахад эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохицуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх, эдгээр асуудлуудтай холбоотой судалгаа, үнэн зөв мэдээллээр яамны холбогдох нэгж, албан тушаалтныг хангах, эмийн зөв хэрэглээ, арга зүйгээр эмнэлгийн мэргэжилтнийг хангах, иргэд олон нийтэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, үндэсний эмийн үйлдвэрлэлийн фармакопейн өгүүллийг хянах, баталгаажуулах, нэвтрүүлэх, судалгаа мэдээллийн сан бий болгох, мэдээлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ЭМЯ-ны эм, үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага (сайд, дэд сайд, ТНБД), төвийн Ерөнхий захираг, энэ үйлчилгээг шууд бус хэрэглэгч нь яамны бусад зохион байгуулалтын нэгж, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрүүд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, хил, гааль, хууль, мэргэжлийн хяналтын байгууллага, эмнэлзүйн сургалтын байгууллагууд, эм үйлдвэрийн импортлогч байгууллагууд, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагууд байна.

## 7.6. Чанар, магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.5-ын хүрээнд:

7.6.1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудад

чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

7.6.2. Эрүүл мэндийн байгууллагын чанарын албыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах, зөвлөн туслах, чанар сайжруулах арга хэрэгслийг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах;

7.6.3. Эрүүл мэндийн салбарын Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн ажлын албаны үүрэг гүйцэтгэж, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, орон тооны бус шинжээчдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, шинжээчдийн багийг арга зүйн удирдамжаар ханган ажиллах, хяналт тавих;

7.6.4. Магадлан итгэмжлэлийн бэлтгэл хангуулах чиглэлээр аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллах;

7.6.5. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний алдаа, зөрчлийн бүртгэлийн мэдээний сан бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, алдаанаас сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагуудын тусlamж, үйлчилгээний эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх;

7.6.6. Эрүүл мэндийн байгууллагуудын хүлээгдлийн мэдээ, үйлчилүүлэгчдийн сэтгэл ханамж, тусlamж, үйлчилгээний чирэгдлийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийн, нэгтгэж, тайлagnah, холбогдох байгууллагуудад зөвлөж туслах;

7.6.7. Эмнэлзүйн заавар, удирдамж, стандартын хэрэгжилт, өвчний оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийн талаар мэдээний сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах.

7.6.8. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмж, донорын бүртгэл, мэдээний санг бүрдүүлж, яам, эмнэлгүүдийг мэдээллээр хангаж ажиллах;

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах болон эмнэлгийн тусlamжийн чанарын тасралтгүй хөгжлийг хангахад Эрүүл мэндийн яаманд судалгаа, мэдээллээр хангаж ажиллах, эмнэлгийн тусlamж үйлчилгээний алдаанаас сэргийлэх, эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, хамтран ажиллах, эмнэлзүйн удирдамж, заавар, стандартын боловсруулалт, хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт танилцуулах, магадлан итгэмжлэлийн зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэх, эмнэлзүйн чанарын албыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, эдгээр үйл ажиллагааг эмнэлгийн байгууллагууд, мэргэжлийн нийгэмлэгүүд, холбоод, олон улсын байгууллагууд, ТББ-уудтай хамтран ажиллах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ЭМЯ-ны эмнэлгийн тусlamжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага (сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга), төвийн Ерөнхий захирал, дэд захирал байна. Энэ үйлчилгээг шууд бус хэрэглэгч нь яамны бусад зохион байгуулалтын нэгж, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүд, иргэд бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжлийн хяналтын бүх шатны байгууллага, олон улсын байгууллага, яамны мэргэжлийн салбар зөвлөлүүд байна.

#### **7.7.Захиргаа, санхүү, үйлчилгээний асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.7-ийн хүрээнд:

7.7.1 Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэнд хяналт тавих, байгууллагын удирдлагыг шийдвэр гаргахад хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх;

7.7.2.Төвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдох үндсэн чиглэлийг алба, нэгжүүдэд өгөх, нэгжийн дарга нарын боловсруулсан тушаал, шийдвэрийн төслийг хянах;

7.7.3.Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг оновчтой хийж, ажилтнуудын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах;

7.7.4.Байгууллагын хэмжээнд нийт ажилтан албан хаагчдын сахилга, дэг журам, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах, ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хяналт тавих;

7.7.5.Байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлэх шалгуурыг судалгаанд үндэслэн боловсруулах, нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих;

7.7.6.Байгууллагын төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулж, батлагдсан төсвийг оновчтой, зөв зарцуулж тайлагнах, санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу явуулах;

7.7.7.Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, санхүүгийн болон үйл ажиллагааны бүртгэл тооцоог олон улсын нягтлан бodoх бүртгэлийн стандартын дагуу хөтлөх, тайлан мэдээг хууль журмын дагуу гаргах, холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх;

7.7.8.Төвийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооны шийдвэр болон олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах буюу шилжилт хөдөлгөөн хийх, данснаас хасах, борлуулах, устгах;

7.7.9.Төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангаж “Шилэн дансны тухай”-хуулийн хүрээнд санхүүгийн мэдээллийг байгууллагын веб сайтад тогтмол байршуулах, ил тод нээлттэй байх үйл ажиллагааг зохион байгуулах;

7.7.10.Салбар болон салбар дундын уялдаа холбоог нягтруулж, хамтын ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу өргөжүүлэх;

7.7.11.Гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлж, олон улсын чиг хандлагатай уялдуулан өөрийн орны онцлогт тохируулан төвийн үйл ажиллагааг хөгжлийн шинэ шатанд хүргэх, шинэ гэрээ, хэлэлцээр, протокол, санамж бичгийн агуулга, үзэл санааг салбарын бодлого, чиглэлийн дагуу шинэчлэн баяжуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.7.12.Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулах дэмжлэгт орчин, үйл ажиллагааны ил тод байдлыг бүрдүүлэн ажиллах;

7.7.13.Архив, албан хэрэг хөтлөлт, албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих;

7.7.14.Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтад суралцах хугацаанд нь байраар хангах ажлыг зохион байгуулах;

7.7.15.Төвийн үйл ажиллагааны автоматжуулалт, цахим тоног төхөөрөмжийн найдвартай үйл ажиллагааг бүрдүүлэх;

7.7.16.Байгууллагын нэгжийн үйл ажиллагаанд дотоодын хяналт үнэлгээний үйл ажиллагааг бие даасан, хараат бус байдлаар хийх, нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

7.7.17.Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн ажил, үүргээ гүйцэтгэх боломжийг хангах, төвийн удирдлага, хүний нөөц, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, төвийг тогтвортой санхүүжилттэй байлгах, ажиллагсадын нийгмийн баталгааг бодлого, хууль эрхийн дагуу хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь төвийн Ерөнхий захирал, дэд захирал, бүтцийн нэгжүүд, нийт ажиллагсад байна. Энэ үйлчилгээг шууд бус хэрэглэгч нь ЭМЯ-ны санхүү, хөрөнгө оруулалтын асуудал болон төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвш нь Сангийн яам, ЭМЯ-ны зохион байгуулалтын бүтцийн холбогдох нэгжүүд, эмнэлгийн байгууллагууд, олон улсын байгууллагууд байна.

## Найм. Бусад

8.1.Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох эрх зүйн бичиг баримтаар зохицуулна.

-оо-



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН БҮТЭЦ

